

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын
бүтэц, орон тооны хязгаарыг
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.4.3.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр, орон тооны хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан компанийн хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тогтоолыг 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ